



**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

**TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA  
SHAREHOLDERS MEETING RESOLUTION**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан  
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дурмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Худалдаа, хөгжлийн банкны 2023 оны жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралтын дагуу баталсугай.

## ХУВЬЦАА ЭЗЭМ ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа  
эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ны  
өдрийн ээлжит хурлын 01 тоот тогтоолын  
хавсралт



**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Энэхүү дүгнэлтийг Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” гэх)-ийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны зохистой засаглалын зарчим, Компанийн засаглалын кодекс болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар хэлэлцэн гаргаж байна.

ХХБ төдийгүй банкны сектор нь томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг хийж, системийн нөлөө бүхий банкууд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг нээлттэй хувьцаат компани болж, банкны секторын нийт актив жилийн 24.2 хувийн өсөлт үзүүлж, 57.0 их наяд төгрөгт хүрч, цар тахлын нөлөө буурч, эдийн засаг сэргэж, банкны ашигт ажиллагаа сайжирсан зэрэг амжилт, бүтээлээр 2023 оныг үдэж, Монгол Улсад банкны систем үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж байна.

Хувьцаат компани болсонтой холбогдуулан олон талт, ур чадвартай боловсон хүчинээр ТУЗ-ийн гишүүдийн тоо нэмэгдэж, банкны бизнесийг дэмжих, өргөжүүлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх зэрэг өргөн хүрээний чиглэл, зөвлөмжийг өгөх бололцоог бүрдүүлсэн. ХХБ-ны ТУЗ нь 2023 онд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг тус тус мөрдлөг болгож, ТУЗ, түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэр, зөвлөмж зэргээр ХХБ-ны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хичээн ажиллаа.

Түүнчлэн, 2023 оны банкны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ТУЗ-ийн гишүүдийн хараат бус байдлаар гаргасан үнэлгээний үр дүнд суурилан гаргасан болно.

ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагаас эхлэн нийт ажилтнууд нь тус банкны (i) Харилцагч төвтэй банк болох, (ii) Олон улсын банк болох, (iii) Платформ банк болох урт хугацааны зорилгуудын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж, нийт активыг 12.1 их наяд, хуримтлагдсан ашгийг 151.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн амжилттай ажилласан байна.

#### *Урт хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө*

##### **Харилцагч төвтэй банк болох**

Үйлчилгээний төгөлдөршилийн олон улсын стандартууд болох ISO235952 болон ISO9001:2015-г Монгол Улсад анхлан нэвтрүүлж, харилцагчдын туршлага болон сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд төвлөрч, "Бритто Лоялти", "Хуримтлалтай Монгол", "Genesys" дуудлагын төвийн системийн шийдэл болон бусад банкнуудтай хамтран ATM-н шимтгэлээ бууруулах зэргээр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, харилцагч нартаа илүү ойртсон. Бүх сегментийн харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн Software POS, Онлайн цалин, тэтгэвэр, ПОС барьцаалсан зээл, Факторингийн үйлчилгээ гэх мэт олон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй санал болгож байна.

##### **Олон улсын банк болох**

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын саарал жагсаалтаас гарснаас хойш Америкийн Нэгдсэн Улсын BNY Mellon банканд ам.долларын ностро данс нээсэн анхны банк болж, харилцагчид гадаад мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг илүү хялбар, бодит цагийн горимоор, шимтгэл багатайгаар хүргэх боломжийг олгосон. Түүнчлэн, Монгол Улсаас анх удаа ХХБ Дэлхийн эдийн засгийн форумтай албан ёсны түвш болж, Mitsui & Co., Ltd. компанийтай хамтран Зэсийн Экспортыг дэмжих санхүүжилтийг амжилттай олгож, Bank of China-тай стратегийн түвшинд хамтран ажиллах санамж бичиг үзэглэсэн.

##### **Платформ банк болох**

API gateway удирдлагын платформыг амжилттай нэвтрүүлж, Open API үйлчилгээг бүрэн ашиглахад бэлэн болгосон. Банкны суурь систем болох Temenos Transact 24, дижитал банкны платформ Temenos Infinity-г нэвтрүүлэх ажлыг амжилттай үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Цалин, тэтгэврийн болон ПОС барьцаалсан зээлийг цахимаар авах боломжтой болгож, цалингийн зээлийн 75.4%, тэтгэврийн 22.4%, ПОС барьцаалсан зээлийн 50.3% нь цахимаар шийдэгдэв. Цаасгүй лайт салбараа шинээр нээж, харилцагчдад цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ санал болгож байна.

## ***Санхүүгийн үзүүлэлт***

ХХБ нь 2023 онд хүүгийн орлогыг 13.4 хувиар, шимтгэл хураамжийн орлого 21.2 хувиар өсгөж, чанаргүй зээлийг 15.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулснаар 151.2 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан ба ХХБ-ны өөрийн хөрөнгийн хэмжээ 19.6 хувиар өсөж, 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн, 2023 оны эцсийн байдлаар ХХБ нь Банкны секторын нийт активын 21.3 хувь, нийт зээлийн 19.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.1 хувь, нийт ашгийн 11.9 хувийг тус тус бүрдүүлж Монгол Улсад төдийгүй олон улсын нэр хүнд бүхий байгууллагын байр сууриа хадгалж, өргөжүүлэн ажилласан байна.

## ***Нийгмийн хариуцлага***

Монгол Улсынхаа хөгжил дэвшилд хөрөнгө оруулалт хийхийг зорьж, олон төсөл хөтөлбөрүүдийг зохион байгуулж, ивээн тэтгэгчээр ажилласан төдийгүй санхүүгийн боловсролыг түгээх, байгаль орчин, нийгэм засаглалыг сайжруулах аяны хүрээнд Save The Planet, эмч эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудалд тус дэм болох зорилготой орон сууцны зээлийг шийдвэрлэх, Худалдааны санхүүжилтийн форум зохион байгуулах, ажилтнуудынхаа цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа. Мөн хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжүүлж байна.

Түүнчлэн, ХХБ нь “БҮС ба ЗАМ санаачилга ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (GIP)”-аас шалгаруулдаг “GIP AWARDS 2023”-н “Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ” үзүүлэгч байгууллага, “Тогтвортой санхүүжилтийн холбоо”-ны Онцлох ТоC банк, “World Economic Magazine” сэтгүүлийн “Best Bank for Remittances Mongolia 2023”-аар тус тус шалгарсан байна.

Эх үүсвэрийг төрөлжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага үүсэж байгаа хэдий ч чанаргүй зээл, Монгол Улсын уул уурхайн салбарын хамаарал болон олон улсын зах зээлүүдэд суурь хүү өсөж байгаа нь эх үүсвэрийн өртгийг нэмэгдүүлж байгаа тул энэхүү сорилтуудыг давж ажиллах зорилтыг тавьж ажиллах арга хэмжээг авах нь зохистой байна.

ТҮЗ-ийн зүгээс банкны Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудаа 2023 оны гүйцэтгэл, амжилтдаа суурилан батлагдсан төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, зах зээлд эзлэх байр сууриа тэлэх, харилцагч, хамтрагч, түншүүддээ зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэмэгдүүлэх, хялбаршуулах, хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээнүүдийг авч ажиллах чиглэл,

Зөвлөмжийг хэрэгжүүлэн одоогийн байр сууриа нэмэгдүүлэн 2024 ондоо өндөр гүйцэтгэлтэй ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өөрсдийн мэдлэг чадвараа банкныхаа хөгжил дэвшилд нэмэрлэн, хамтран ажиллах бөгөөд 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн Худалдаа, хөгжлийн банкийг 2023 онд “хангалттай сайн” ажилласан гэж дүгнэж байна.

#### ХӨГЖИЛД ХАМТДАА

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн  
удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024-2025 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 5,000,000,000.00 (таван тэрбум) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х/Үргэлж

Н.НЯМСҮРЭН